



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 0/21

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 266 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Арвайхээр, Баянгол, Зүүнбаян-Улаан, Төгрөг, Өлзийт, Тарагт, Гучин-Ус суманд урьд гарсан өвчний халдвараас эрсдэлтэй нөхцөл байдал үүсч, мал, амьтны гоц халдварт хонь ямааны цэцэг өвчний халдвар нэмэгдсэнтэй холбогдуулан 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд хорио цээр хязгаарлалтын дэглэмийг хэрэгжүүлэх, хөдөлгөөнт эргүүл зохион байгуулахад гарсан шатахууны зардал болон бусад зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2. Гамшгаас хамгаалах тухай хуулийн холбогдох заалтын дагуу өвчний голомтот нутагт бог малын шилжилт хөдөлгөөн хийхгүй байх, Засаг даргын захирамж гарган хөдөлгөөнт эргүүлд ажиллах бүрэлдэхүүнийг томилж, үүрэг гүйцэтгэж буй байдалд нь байнгын хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Мал, амьтны гоц халдварт хонь, ямааны цэцэг өвчний хязгаарлалт, хорио цээрийн дэглэмийг хэрэгжүүлэх, дархлаажуулалтын ажлыг оновчтой зохион байгуулж, тэмцэх ажилд малчид, иргэдийн оролцоог сайжруулж, санхүүгийн тайланг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Мал эмнэлгийн газарт ирүүлэхийг сумын Засаг дарга нарт, батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, хөдөлгөөнт эргүүлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, дүнг нэгтгэн танилцуулахыг Мал эмнэлгийн газар (А.Нямдаваа)-т даалгасугай.

4. Мал, амьтны гоц халдварт хонь, ямааны цэцэг өвчний хязгаарлалтын дэглэмийг хэрэгжүүлэх, тэмцэх ажилд шаардлагатай санхүүжилтийн 19,498,409 (Арван есөн сая дөрвөн зуун ерэн найман мянга дөрвөн зуун ес) төгрөгийг аймгийн гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0051



**ХОНЬ, ЯМААНЫ ЦЭЦЭГ ӨВЧНИЙ ГОЛОМТТОЙ БҮС НУТАГТ МАЛЫН ШИЛЖИЛТ
ХӨДӨЛГӨӨНД ХЯНАЛТ ТАВИХ ХӨДӨЛГӨӨНТ ЭРГҮҮЛ, СЭЖИГТЭЙ БҮСЭД
ТАНДАЛТ ҮЗЛЭГ ХИЙХЭД ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

1. Шатахууны зардал

Д/д	Үйл ажиллагаа	Нийт км	Зарцуулах шатахуун (литр)	Нийт дүн
1	Цэцэг өвчний голомттой бүс нутагт малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих хөдөлгөөнт эргүүл, тандалт үзлэг хийх	14,640	23	8,949,070
2	Мал эмнэлгийн газраас цэцэг өвчний голомттой бүс нутагт тандалт судалгаа хийх, хяналт шалгалт хийх (12 дугаар сарын 26-ны өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр хүртэлх хугацаанд 3 чиглэлд ажилласан.)	1420	23	839,369
3	Мал эмнэлгийн газраас 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 25-ны хүртэлх хугацаанд 11 суманд 53 малын эмч ажиллуулах	3700	23	2,101,970
Дүн		19,760	23	11,890,409

2. Томилолтын зардал

Д/д	Үйл ажиллагаа	Нийт хүний тоо	Ажиллах хоног	Зарцуулах томилолт буудал	Нийт дүн
1	Мал эмнэлгийн газраас цэцэг өвчний голомттой бүс нутагт тандалт судалгаа хийх, хяналт шалгалт хийх (12 дугаар сарын 26-ны өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр хүртэлх хугацаанд 3 чиглэлд ажилласан.)	11	3	64,000	2,112,000
2	Мал эмнэлгийн газраас 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 25-ны хүртэлх хугацаанд 11 суманд 53 малын эмч ажиллуулах	14	3	64,000	2,688,000
		39	3	24,000	2,808,000
Томилолт нийт дүн		64	3	-	7,608,000
Шатахуун нийт дүн					11,890,409
Нийт дүн					19,498,409